

“2025 ОНЫ ШИЛДЭГ САЙН ДУРЫН ҮЙЛСТЭН” ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ УДИРДАМЖ

САЙН ДУРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН СҮЛЖЭЭ (СДБС)-ээс “Оны шилдэг сайн дурын үйлстэн” шалгаруулах уралдааныг 2008 оноос эхлэн жил бүр явуулж байгаа бөгөөд энэ нь СДБС-ний оюуны бүтээл дээр үндэслэсэн уламжлалт брэнд арга хэмжээ юм.

Нэг. Зорилго

1. Сайн дурын үйл ажиллагааны хөгжилд бодит хувь нэмэр оруулж буй байгууллага хамт олон, хувь хүмүүсийн ажлыг хөхүүлэн дэмжиж, олон нийтийн хүртээл болгон дэлгэрүүлэх, сурталчилах.
2. Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хамт олон, хувь хүмүүст сайн дурын үйл ажиллагааны талаар ойлголт өгөх, цаашид энэ чиглэлд олон талт үйл ажиллагааг зохион байгуулахад уриалах.
3. Сайн дурын үйл ажиллагаанд идэвхи санаачлага, зүтгэлтэй ажиллаж байгаа албан байгууллага, хувь хүмүүсийг дэмжин, тэдэнд сайн дурын үйл ажиллагааны таатай орчныг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах.

Хоёр. Хамрах хүрээ

Улаанбаатар хотод болон Монгол улсын хэмжээнд сайн дурын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн аж ахуй нэгж, хувь хүмүүс оролцоно.

Гурав. Шалгаруулах номинацийн төрөл, шалгуур үзүүлэлт

1. Шилдэг сайн дурын байгууллага

- Монгол улсын хуулийн этгээд байна.
- 2025 онд Монгол Улсын нутаг дэвсгэрт сайн дурын үйл ажиллагааг удирдан зохион байгуусан байгууллага байна.
- Сайн дурын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо (сонгон шалгаруулалт, элсэлт, сургалт, дэмжлэг, үнэлгээ)-ны бүх хүрээг цогцоор нь нэвтрүүлэн хэрэгжүүлж буй байгууллага байна (нотлох).
- Олон талт сайн дурын хөтөлбөр, санаачлага хэрэгжүүлдэг байх.
- Сайн дурын үйл ажиллагааны бүртгэл, мэдээллийн сан нь тоо, чанарын үзүүлэлтээр баталгаажсан байх.
- Сайн дурын хөтөлбөрийн ашиг хүртэгч нарт үзүүлсэн үйлчилгээ, түүний үр дүн% үр өгөөж (нотлох).
- Сайн дурын үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх, бэхжүүлэх, хөгжүүлэхэд оруулсан хувь нэмэр (бататгах).
- Сайн дурын ажилд оролцогч талуудыг өргөн хүрээнд хамруулсан байх (нэрлэх).
- Сайн дурын үйл ажиллагааг төрийн бодлогод тусгахад дорвитой үр дүнд хүрсэн байдал (бататгах).
- 2025 онд байгууллагын сайн дурын ажилд оролцсон сайн дурынхан, зарцуулсан цаг болон үйл ажиллагааны төрөл (нийт сайн дурынхны тоо, ажилласан цаг, гүйцэтгэсэн сайн дурын ажлын төрөл, Тогтвортой хөгжлийн 17 зорилгын алинд хамрах зэргийг тодорхой бичих).

2. Шилдэг сайн дурын үйл ажиллагаа

- 2025 онд Монгол Улсад хэрэгжсэн сайн дурын үйл ажиллагаа байх.
- Нэг буюу хэдэн сайн дурын үйл ажиллагаа (төсөл, хөтөлбөр, санаачлага) байж болно (товч танилцуулга).
- Нэг буюу хэдэн байгууллага, бүлэг хүмүүс хамтарч хэрэгжүүлсэн байж болно (нэрлэх).
- Шинийг эрэлхийлсэн, шинэлэг, ололт, нээлт бүхий үйл ажиллагаа байх.
- Сайн дурын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл амжилттай, үр дүн гарсан байх (бататгах).
- Сайн дурын үйл ажиллагаа нь олон нийтэд чиглэсэн, олон хүнд чанартай үйлчилгээ үзүүлсэн байх (бататгах).
- Өргөн хүрээний оролцогч талуудыг хамруулан гүйцэтгэсэн байх (нэрлэх).
- Сайн дурын үйл ажиллагааны баримтжуулалт сайн хийгдсэн байх (нотлох).
- Сайн дурын ажилд оролцсон сайн дурынхан, зарцуулсан цаг болон үйл ажиллагааны төрөл (хамрагдсан сайн дурынхны тоо, ажилласан цаг, гүйцэтгэсэн сайн дурын ажлын төрөл, Тогтвортой хөгжлийн 17 зорилгын алинд хамрах зэргийг тодорхой бичих).

3. Оны шилдэг сайн дурын ажилтан

- 2025 онд Монгол Улсад хэрэгжсэн, хийсэн сайн дурын үйл ажиллагааг үндэс болгоно.
- Сайн дурын үйл ажиллагаанд бодит амжилт, ахиц гаргасан байх.
- Сайн дурын ажил нь олон нийтэд эерэг өөрчлөлт, үр нөлөө үзүүлсэн (нотлох).
- Сайн дурын үйл ажиллагаанд ахиц, өөрчлөлт гаргасан (нотлох).
- Бусдыг сайн дурын ажилд уриалсан, татан оролцуулсан, дэмжсэн байх (татан оролцуулсан хүний тоо).
- Сайн дурын үйл ажиллагаанд шинэ, шинэлэг ололт, арга замыг нэвтрүүлсэн байх (нотлох).
- 2025 онд сайн дурын ажилд зарцуулсан цаг болон үйл ажиллагааны төрөл (нийт ажилласан цаг, гүйцэтгэсэн сайн дурын ажлын төрөл, Тогтвортой хөгжлийн 17 зорилгын алинд хамрах зэргийг тодорхой бичих).

4. Оны шилдэг залуу сайн дурын ажилтан

- 25 хүртлэх насны сайн дурын ажилтан байна (2025.12.05-ны өдрийн байдлаар 25 нас хүрээгүй байх)
- 2025 онд Монгол Улсад хэрэгжсэн сайн дурын үйл ажиллагааг үндэс болгоно.
- Сайн дурын үйл ажиллагаанд бодит амжилт, ахиц гаргасан байх.
- Сайн дурын үйл ажиллагаанд ахиц, өөрчлөлт гаргасан (нотлох).
- Бусдыг сайн дурын ажилд уриалсан, татан оролцуулсан, дэмжсэн байх (татан оролцуулсан хүний тоо).
- Сайн дурын үйл ажиллагаанд шинэ, шинэлэг ололт, арга замыг нэвтрүүлсэн байх (нотлох).
- 2025 онд сайн дурын ажилд зарцуулсан цаг болон үйл ажиллагааны төрөл (нийт ажилласан цаг, гүйцэтгэсэн сайн дурын ажлын төрөл, Тогтвортой хөгжлийн 17 зорилгын алинд хамрах зэргийг тодорхой бичих).

Дөрөв. Шалгаруулах журам

1. Нэр дэвшигчид холбогдох материалыг СДБС-ны зохицуулагч байгууллага болох “Амгалан айл” ТББ-д 2025 оны 11 сарын 24-ны дотор ирүүлнэ.

2. 2025 оны 11 сарын 30-ны дотор салбар тус бүрийн төлөөлөл бүхий шинжээчдийн хараат бус баг шалгаруултыг хийнэ.
3. Шалгаруулалтыг дүнг Олон Улсын Сайн Дурынхны Өдөр буюу 2025 оны 12 сарын 5-ны өдөр Улаанбаатар хотод болох ёслолын арга хэмжээн дээр зарлана.

Тав. Нэр дэвшигчдийн бүрдүүлэх материал

1. Нэр дэвшигчийн анкет/маягт.
2. Тухайн нэр дэвшигчийн ажил байдлын тодорхойлолт (өөрийн байгууллага эсвэл сайн дурын ажил хийсэн байгууллагын).
3. Нэр дэвшигчийг дэмжсэн 1-2 албан бичиг/тодорхойлолт (хамтран ажиллагч болон дэмжигч байгууллага, хувь хүн, гэх мэт).
4. Хийсэн болон оролцсон сайн дурын үйл ажиллагааны тайлан.
5. Баримтжуулсан байдал (үйл ажиллагаа, өөрчлөлтүүд, үр дүнг харуулсан чанар сайтай фото зураг, видео бичлэг, рийлс, гэх мэт.)

Мэдээл өгөх, материал хүлээн авах хаяг

“Амгалан Айл” ТББ

Хаяг: БЗД, 6-р хороо, Эрхэт оффис, 706 тоот

Холбоо барих утас: 9055-9055, 8802-9845

Имэйл хаяг: volunteering.mongolia@gmail.com

ЗУРАГ

**“2025 ОНЫ ШИЛДЭГ САЙН ДУРЫН ҮЙЛСТЭН”
ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНД НЭР ДЭВШҮҮЛЭХ МАЯГТ**

НЭР ДЭВШИГЧИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ	
Овог, нэр	
Нас, хүйс	
Регистрийн дугаар	
Байгууллага/гэрийн хаяг	
И-мэйл хаяг	
Фэйсбүүк хаяг (бусад сошиал хаяг)	
Утас	
Боловсрол	
Ажил эрхлэлт	
Дэвшиж буй номинацийн нэр	
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХАНГАСАН БАЙДАЛ	
Нэр дэвшигч нь энэ номинацийн хүрээнд 2025 онд сайн дурын ямар үйл ажиллагаа явуулсан тухайгаа тодорхой бичнэ үү (300 үг дотор)	
Нэр дэвшигчийн хийсэн ажил, бүтээлээс 2025 онд сайн дурын үйл ажиллагаанд гарсан ахиц, өөрчлөлт, үр дүн, үр нөлөөг нотлох, хэмжигдэх үзүүлэлтээр илэрхийлнэ үү (300 үгээс хэтрэхгүй).	
Баримтжуулсан байдал: үйл ажиллагаа, өөрчлөлт, үр дүнг харуулсан фото зураг, видео бичлэг, рийлс зэргийг хавсаргаж мэйлдэх. Өөр холбогдох материал байвал хавсаргаж болно.	
НЭР ДЭВШҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ	
(Хувь хүн өөрийгөө нэр дэвшүүлж буй тохиолдолд доорх мэдээллийг алгасаж болно)	
Нэр дэвшүүлж буй байгууллагын нэр	
Албан тушаалтны овог, нэр	
Албан тушаал	
Байгууллагын хаяг	
Харилцах утас	
И-мэйл хаяг	
Вэб болон фэйсбүүк хаяг (бусад сошиал хаяг)	

Энэ маягтыг бүрдүүлэх болон хавсралт материалын хамт дугтуйлж
2025 оны 11-р сарын 24-ний дотор дараах хаягаар ирүүлнэ үү.

“АМГАЛАН АЙЛ” ТББ

Хаяг: БЗД, 6-р хороо, Эрхэт оффис, 706 тоот

Холбоо барих утас: 9055-9055, 8802-9845

Имэйл хаяг: volunteering.mongolia@gmail.com